



ДУНДГОВЬ АЙМАГ  
АДААЦАГ СҮМҮН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 07 өдөр

Дугаар 24

Тавин

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, 47 дугаар зүйлийн 47.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 103 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орох иргэний мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх тухай журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх Хог тээврийн авто машины ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Салбар зөвлөлийн дарга: Г.Дэжидсүрэн (Дэлгэрцогт сумын Нягтлан бодогч)

Нарийн бичгийн дарга: О.Ганбаатар (Хөдөө аж ахуйн тасгийн

мэргэжилтэн)

Гишүүд: Б.Баттогтох (Байгаль орчны мэргэжилтэн)

Б.Довуучий (Багийн Засаг дарга)

Х.Туяажаргал (Иргэний төлөөлөл)

2. Тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Г.Дэжидсүрэн)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (О.Ганбаатар)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ч.УРАНЧИМЭГ